ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2023/12/НА-СТА-ТТЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.ov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Долгоржав<br>Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn<br>Аудитор: Э.Булганчимэг<br>Утас: 261628 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/835
танай ______________-ны № ______________-т

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА С.БАТБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Стандарт, хэмжил зүйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулаагүй ажилтнуудад цалин, урамшуулал илүү, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосон, хөрөнгийг дутуу тайлагнасан 336.6 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5. дах заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Стандарт, хэмжил зүйн газар нь Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэн, олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх, итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, бүтээгдэхүүнд сорилт шинжилгээ хийх чиглэлээр 9 нэгж, дэргэдэх байгууллага 1,

орон нутаг дахь 21салбар хэлтсийн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 417 дугаар тогтоол, 2022 оны "Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 469 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж, Шадар сайдын "Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2023 оны 05 дугаар тушаалаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төв лабораторийг 2023 онд Стандарт, хэмжил зүйн газарт нэгтгэсэн байна.

Мөн Шадар сайдын 2023 оны 21 дүгээр тушаалаар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийг Стандарт, хэмжил зүйн газрын дэргэд байгуулж, бүтцийг баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсанаар тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 114 дүгээр тогтоол, 2023 оны 109 тогтоолоор нийт 28,813.2 сая төгрөг, Нийслэлийн Засаг даргын а/855 дугаар захирамжаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 1,960.8 сая төгрөг нийт 30774.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, мөн 1092.8 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд стандарт, хэмжилт, баталгаажуулалтын салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 16 зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт 96 хувийг гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*(мянган төгрөгөөр)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,916,768.2** | **1,881,114.7** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 28,273.5 | 37,673.0 |
| 33 | АВЛАГА | 1,071,873.9 | 220,260.9 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 816,620.8 | 1,623,180.7 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,722,726.3** | **27,688,766.8** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 9,722,726.3 | 27,688,766.8 |
| 39200 | Биет хөрөнгө | 9,126,515.3 | 26,559,929.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 596,211.0 | 1,128,837.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **11,639,494.5** | **29,569,881.5** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **67,869.8** | **270,643.9** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 67,869.8 | 270,643.9 |
| 41300 | Өглөг | 67,869.8 | 268,993.9 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 0.0 | 1,650.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,571,624.7** | **29,299,237.6** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 11,571,624.7 | 29,299,237.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 6,914,337.3 | 9,474,838.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,609,486.3 | 17,701,022.9 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,047,801.1 | 2,123,376.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,639,494.5** | **29,569,881.5** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*(мянган төгрөгөөр)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **13,191,970.4** | **31,176,295.3** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 9,978,139.1 | 17,791,878.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 9,978,139.1 | 17,791,878.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,213,831.3 | 13,384,416.5 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **11,861,804.1** | **24,492,139.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,861,804.1** | **24,492,139.7** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,774,813.8 | 20,966,847.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,508,835.7 | 12,469,640.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 565,440.4 | 1,532,266.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 386,373.0 | 1,321,735.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 359,044.5 | 491,736.9 |
| 2105 | Нормативт зардал | 274,919.0 | 602,821.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 876,933.0 | 482,782.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 197,449.4 | 341,740.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 358,394.7 | 635,300.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,247,424.1 | 3,088,823.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,086,990.4 | 3,525,291.9 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **1,330,166.3** | **6,684,155.6** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **128,647.5** | **288,171.1** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **1,201,518.8** | **6,395,984.5** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*(мянган төгрөгөөр)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 13,064,675.9 | 22,568,797.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,798,237.2 | 9,119,310.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,798,237.2 | 9,119,310.4 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 5,266,438.6 | 13,449,486.5 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,544,275.2 | 21,943,920.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 11,544,275.2 | 21,943,920.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,258,628.1 | 18,407,978.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,511,830.7 | 12,448,270.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 538,069.4 | 1,564,531.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 384,458.0 | 1,119,567.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 247,120.1 | 367,004.2 |
| 2105 | Нормативт зардал | 194,327.9 | 552,645.9 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,091,428.5 | 694,445.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 198,383.3 | 324,003.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 331,662.3 | 616,558.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 761,347.8 | 720,951.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,285,647.2 | 3,535,942.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 1,520,400.6 | 624,876.8 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 1,498,656.4 | 615,477.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,498,656.4 | 615,477.3 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,498,656.4 | 615,477.3 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | -1,498,656.4 | -615,477.3 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 21,744.3 | 9,399.5 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,529.2 | 28,273.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,273.5 | 37,673.0 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*
*(мянган төгрөгөөр)*

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,344,862.7 | 0.0 | 10,344,862.7 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 26,511.3 | 0.0 | 26,511.3 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,371,374.0 | 0.0 | 10,371,374.0 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (8,674.1) | 0.0 | (8,674.1) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 7,406.0 | 0.0 | 7,406.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 1,201,518.8 | 0.0 | 1,201,518.8 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 11,571,624.7 | 0.0 | 11,571,624.7 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 11,331,628.4 | 0.0 | 11,331,628.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 22,903,253.1 | 0.0 | 22,903,253.1 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 6,395,984.5 | 0.0 | 6,395,984.5 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 29,299,237.6 | 0.0 | 29,299,237.6 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **19,354,002,300.00** | **18,984,440,646.00** | **369,561,654.00** | 98.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **19,354,002,300.00** | **18,984,440,646.00** | **369,561,654.00** | 98.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **18,420,825,100.00** | **18,168,548,782.14** | **252,276,317.86** | 98.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **12,389,756,400.00** | **12,280,210,482.52** | **109,545,917.48** | 99.1 |
| 210101 | Үндсэн цалин | 7,896,652,000.00 | 7,863,705,972.56 | **32,946,027.44** | 99.6 |
| 210102 | Нэмэгдэл | 2,872,795,700.00 | 2,791,490,480.77 | **81,305,219.23** | 97.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 989,274,900.00 | 1,052,771,320.95 | **(63,496,420.95)** | 106.4 |
| 210104 | Урамшуулал | 631,033,800.00 | 571,784,633.24 | **59,249,166.76** | 90.6 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 458,075.00 | **(458,075.00)** | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,567,397,500.00** | **1,543,848,795.73** | **23,548,704.27** | 98.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,063,852,300.00 | 1,053,013,055.32 | **10,839,244.68** | 99.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 125,886,400.00 | 124,105,668.03 | **1,780,731.97** | 98.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 100,709,000.00 | 98,473,878.60 | **2,235,121.40** | 97.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 25,177,200.00 | 24,374,565.91 | **802,634.09** | 96.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 251,772,600.00 | 243,881,627.87 | **7,890,972.13** | 96.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,110,783,900.00** | **1,054,303,628.25** | **56,480,271.75** | 94.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 252,520,500.00 | 242,112,174.73 | **10,408,325.27** | 95.9 |
| 210302 | Түлш, халаалт | 646,069,900.00 | 618,120,804.19 | **27,949,095.81** | 95.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 80,968,000.00 | 76,038,069.33 | **4,929,930.67** | 93.9 |
| 210304 | Байрны түрээс | 131,225,500.00 | 118,032,580.00 | **13,192,920.00** | 89.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **333,084,700.00** | **328,801,687.11** | **4,283,012.89** | 98.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 80,306,600.00 | 80,607,984.00 | **(301,384.00)** | 100.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 79,546,300.00 | 79,951,400.00 | **(405,100.00)** | 100.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 94,470,300.00 | 91,447,842.11 | **3,022,457.89** | 96.8 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,217,300.00 | 8,340,422.00 | **1,876,878.00** | 81.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 68,544,200.00 | 68,454,039.00 | **90,161.00** | 99.9 |
| **2105** | **Нормативт зардал** | **550,049,500.00** | **542,473,996.39** | **7,575,503.61** | 98.6 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 520,451,400.00 | 513,153,278.39 | **7,298,121.61** | 98.6 |
| 210502 | Хоол, хүнс | 19,032,300.00 | 18,757,818.00 | **274,482.00** | 98.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,565,800.00 | 10,562,900.00 | **2,900.00** | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,010,752,000.00** | **999,966,246.85** | **10,785,753.15** | 98.9 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 696,504,400.00 | 686,159,707.08 | **10,344,692.92** | 98.5 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 27,830,100.00 | 27,784,504.00 | **45,596.00** | 99.8 |
| 210604 | Урсгал засвар | 286,417,500.00 | 286,022,035.77 | **395,464.23** | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **292,034,300.00** | **288,531,047.00** | **3,503,253.00** | 98.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 292,034,300.00 | 288,531,047.00 | **3,503,253.00** | 98.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **659,204,400.00** | **623,120,243.72** | **36,084,156.28** | 94.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 419,976,600.00 | 390,159,619.22 | **29,816,980.78** | 92.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,274,700.00 | 8,237,800.00 | **36,900.00** | 99.6 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,713,900.00 | 5,365,299.00 | **1,348,601.00** | 79.9 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,712,400.00 | 1,925,777.50 | **786,622.50** | 71.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 656,400.00 | 517,500.00 | **138,900.00** | 78.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 79,196,100.00 | 77,966,355.00 | **1,229,745.00** | 98.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 7,123,700.00 | 5,477,283.00 | **1,646,417.00** | 76.9 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 500,000.00 | 146,100.00 | **353,900.00** | 29.2 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 134,050,600.00 | 133,324,510.00 | **726,090.00** | 99.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **507,762,400.00** | **507,292,654.57** | **469,745.43** | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 397,834,600.00 | 397,512,935.57 | **321,664.43** | 99.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 109,927,800.00 | 109,779,719.00 | **148,081.00** | 99.9 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **933,177,200.00** | **815,891,863.86** | **117,285,336.14** | 87.4 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **252,296,600.00** | **252,295,517.86** | **1,082.14** | 100.0 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 252,296,600.00 | 252,295,517.86 | **1,082.14** | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **680,880,600.00** | **563,596,346.00** | **117,284,254.00** | 82.8 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 632,798,100.00 | 517,348,689.00 | **115,449,411.00** | 81.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 48,082,500.00 | 46,247,657.00 | **1,834,843.00** | 96.2 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **19,354,002,300.00** | **18,984,775,046.00** | **369,227,254.00** | 98.1 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **12,324,164,500.00** | **11,561,266,777.47** | **762,897,722.53** | 93.8 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 12,324,164,500.00 | 11,561,266,777.47 | **762,897,722.53** | 93.8 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **7,029,837,800.00** | **7,423,508,268.53** | **(393,670,468.53)** | 105.6 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,999,923,800.00 | 7,419,322,768.53 | **(419,398,968.53)** | 106.0 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 29,914,000.00 | 4,185,500.00 | **25,728,500.00** | 14.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **22** | **22** | **0** | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 22 | 22 | **0** | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **702** | **698** | **4** | 99.4 |
| 620001 | Удирдах ажилтан | 32 | 37 | **(5)** | 115.6 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 560 | 553 | **7** | 98.8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 110 | 108 | **2** | 98.2 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **702** | **698** | **4** | 99.4 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 238 | 238 | **0** | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 464 | 460 | **4** | 99.1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,316,033,804.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,282,404,704.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **974,259,916.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **168,059,567.20** |
| 210101 | Үндсэн цалин | | 82,237,330.36 |
| 210102 | Нэмэгдэл | | 76,607,968.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 3,376,248.13 |
| 210104 | Урамшуулал | | 2,574,901.50 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 3,263,118.81 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **20,682,683.48** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 15,674,732.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 1,339,645.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 1,269,678.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 235,692.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 2,162,934.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | **65,264,113.96** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 1,980,491.04 |
| 210302 | Түлш, халаалт | | 47,287,484.92 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 996,138.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210304 | Байрны түрээс | | 15,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **38,202,553.96** |
| 210401 | Бичиг хэрэг | | 11,237,615.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 19,834,320.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 897,668.96 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 367,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 5,865,950.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **13,009,910.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 11,857,910.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 1,152,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **271,886,122.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 90,941,110.00 |
| 210602 | Тавилга | | 65,020,800.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 1,840,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 114,084,212.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **35,472,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 35,472,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **13,477,376.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,633,126.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 2,950,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 2,894,250.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **348,205,590.10** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 342,971,590.10 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 5,234,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **308,144,787.77** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **289,359,583.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох  бусад тэтгэмж, урамшуулал | | 32,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 257,359,583.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **18,785,204.77** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 18,785,204.77 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **33,629,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **33,629,100.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 33,629,100.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **1,316,033,804.47** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **1,316,033,804.47** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 47,417,040.78 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 385,735,584.36 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 153,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 729,881,179.33 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Стандарт, хэмжил зүйн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 22 байгууллага нэгтгэгдсэнээс 16 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг аудитын хэсэгчилсэн үе шатны аудитад хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 12, “Хязгаарлалттай” 4 дүгнэлт өгсөн.

**Төвлөрүүлэн захирагч**

Албан шаардлага

**1.** Стандарт, хэмжил зүйн газар 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж ирүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам, маягт бэлтгэх журам”-ыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаашид төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар бэлтгэж ирүүлээгүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**2.** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 837.4 сая төгрөгийн 79 алдаа, зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 336.6 сая, нийцлийн асуудалтай холбоотой 312.1 сая төгрөгийн зөрчлүүд байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-т "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалттай хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаашид дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд 2023 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 11,025.1 сая төгрөгийн 546 гүйлгээг байршуулахаас, нийт 1,686.1 сая төгрөгийн 92 ажил гүйлгээг хугацаа хоцроон мэдээлж, 27 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*”, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”* гэсэн

заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

1. Ажилтнуудад ур чадварын нэмэгдлийн хувь хэмжээг шалгуур үзүүлэлтгүйгээр хавтгайруулан тогтоож, олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.3 "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно." гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Ажилтнуудын ажлын гүйцэтгэл, мэдлэг, чадвар, идэвх санаачилгыг үндэслэн тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу ур чадварын нэмэгдлийн хувийг тогтоож, олгож байх

2. Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн өр төлбөр 202.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх, өмнөх онуудад үүссэн өр төлбөрийг барагдуулах

**<u>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал</u>**

Аудитаар нийт 188.7 сая төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Залруулсан | тоо | Залруулаагүй | тоо | Дүн |
| 1 | Архангай аймгийн СХЗГ | 2 | 7,227.1 | | | 2 | 7,227.1 | 2 | 7,227.1 | | | | |
| 2 | Говь-Алтай аймгийн СХЗГ | 1 | 1,837.2 | | | 1 | 1,837.2 | 1 | 1,837.2 | | | | |
| 3 | Говьсүмбэр аймгийн СХЗГ | 4 | 66,780.2 | 3 | 50,982.9 | 1 | 15,797.3 | 4 | 66,780.2 | | | | |
| 4 | Дорноговь аймгийн СХЗХ | 3 | 40662.9 | | | 3 | 40662.9 | 3 | 40662.9 | | | | |
| 5 | Дундговь аймгийн СХЗГ | 6 | 20,841.6 | 2 | 2,103.1 | 4 | 18,738.5 | 6 | 20,841.6 | | | | |
| 6 | Орхон аймгийн СХЗХ | 1 | 839.3 | | | 1 | 839.3 | 1 | 839.3 | | | | |
| 7 | Өмнөговь аймгийн СХЗХ | 1 | 5,223.9 | 1 | 5,223.9 | | | 1 | 5,223.9 | | | | |
| 8 | Төв аймгийн СХЗГ | 4 | 45,026.7 | 2 | 7,816.0 | 2 | 37,210.7 | 4 | 45,026.7 | | | | |
| 9 | Увс аймгийн СХЗХ | 1 | 142.5 | | | 1 | 142.5 | 1 | 142.5 | | | | |
| 10 | Хөвсгөл аймгийн СХЗХ | 1 | 155.0 | | | 1 | 155.0 | 1 | 155.0 | | | | |
| **ДҮН** | | **24** | **188,736.4** | **8** | **66,125.9** | **16** | **122,610.5** | **24** | **188,736.4** | **0** | **0.0** | **0** | **0.0** |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 539.4 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 5.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 221.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 312.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Стандарт хэмжил зүйн газар-ТТЗ | 3 | 202,773.9 | | | 2 | 0.0 | 1 | 202,773.9 | | | | |
| | **Дүн** | **3** | **202,773.9** | | | **2** | **0.0** | **1** | **202,773.9** | | | | |
| 1 | Стандарт хэмжил зүйн газар-ТШЗ | 3 | 73,381.6 | | | 3 | 73,381.6 | | | | | | |
| 2 | Баян-Өлгий аймгийн СХЗХ | 1 | 71,185.3 | | | 1 | 71,185.3 | | | | | | |
| 3 | Баянхонгор аймгийн СХЗХ | 3 | 45,093.0 | 1 | 539.9 | 1 | 4,425.3 | 1 | 40127.7 | | | | |
| 4 | Говь-Алтай аймгийн СХЗГ | 2 | 1,932.0 | | | 2 | 1,932.0 | | | | | | |
| 5 | Говьсүмбэр аймгийн СХЗГ | 2 | 1,770.7 | 1 | 70.0 | 1 | 1,700.7 | | | | | | |
| 6 | Дорноговь аймгийн СХЗХ | 2 | 330.0 | | | | | 2 | 330 | | | | |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Дундговь аймгийн СХЗХ | 3 | 1,959.8 | 2 | 1,959.8 | 1 | 0.0 | | | | | | |
| 8 | Орхон аймгийн СХЗХ | 1 | 393.6 | 1 | 393.6 | | | | | | | | |
| 9 | Өвөрхангай аймгийн СХЗХ | 1 | 9,724.7 | | | 1 | 9,724.7 | | | | | | |
| 10 | Өмнөговь аймгийн СХЗХ | 3 | 244.7 | | | | | 3 | 244.7 | | | | |
| 11 | Сэлэнгэ аймгийн СХЗХ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| 12 | Төв аймгийн СХЗХ | 4 | 20,423.3 | | | 2 | 18,879. | 2 | 1,543.7 | | | | |
| 13 | Ховд аймгийн СХЗХ | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| 14 | Хөвсгөл аймгийн СХЗХ | 3 | 46,746.7 | 1 | 106.7 | | | 2 | 46,640.0 | | | | |
| 15 | Хэнтий аймгийн СХЗХ | 1 | 12,840.0 | | | 1 | 12,840.0 | | | | | | |
| 16 | Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори | 9 | 50,597.2 | 2 | 2,249.3 | 3 | 27,807.1 | 4 | 20,540.8 | | | | |
| | **Дүн** | **40** | **336,622.5** | **8** | **5,319.3** | **16** | **221,876.3** | **16** | **109,426.9** | | | | |
| **ДҮН** | | **43** | **539,396.4** | **8** | **5,319.3** | **18** | **221,876.3** | **17** | **312,200.8** | **0** | **0** | **0** | **0.0** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,998.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1,726.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 271.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Шалгагдагч байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Баян-Өлгий аймгийн СХЗХ | 1 | 32,261.0 | | | | | 1 | 32,261.0 |
| 2 | Баянхонгор аймгийн СХЗХ | 1 | 0 | | | 1 | 0 | | 0 |
| 3 | Дорноговь аймгийн СХЗХ | 1 | 14,523.0 | | | | | 1 | 14,523.0 |
| 4 | Дундговь аймгийн СХЗХ | 1 | 0 | | | 1 | 0 | | 0 |
| 5 | Өмнөговь аймгийн СХЗХ | 1 | 17,000.0 | | | | | 1 | 17,000.0 |
| 6 | ХАБҮЛЛ | 1 | 199,200.0 | | | | | 1 | 199,200.0 |
| 7 | Стандарт хэмжил зүйн газар-ТТЗ | 1 | 1,686,058.9 | | | 1 | 1,686,058.9 | | |
| **Дүн** | | **7** | **1,949,042.9** | **0** | **0.0** | **3** | 1,686,058.9 | **4** | **262,984.0** |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Говь-Алтай аймгийн СХЗХ | 1 | 20,103.0 | | | 1 | 20,103.0 | | |
| 2 | Дорноговь аймгийн СХЗХ | 1 | 8,707.7 | | | | | 1 | 8,707.7 |
| 3 | Сүхбаатар аймгийн СХЗХ | 1 | 0 | | | | | 1 | |
| 4 | ХАБҮЛЛ | 1 | 20,295.9 | | | 1 | 20,295.9 | | |
| 5 | Стандарт хэмжил зүйн газар-ТТЗ | 1 | 0 | | | | | 1 | |
| **Дүн** | | **5** | **49,106.6** | **0** | **0.0** | **2** | **40,398.9** | **3** | **8,707.7** |
| **Нийт дүн** | | **12** | **1,998,149.5** | **0** | **0.0** | **5** | **1,726,457.8** | **7** | **271,691.7** |